

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

**5.1.Ногоон хөгжил.** Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.Азийн хөгжийн банк болон орон нутгийн төсвийн 480,0 сая төгрөгийн санхүүжилтээр “КА-9100-МОН” төслийн хүрээнд Арвайхээр сумын 13 багийн 283 өрх тус төсөлд хамрагдаж сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. 2021 онд голын хамгаалалтын бүс болох Онги, Дайргын голын орчимд стандартын шаардлага хангасан 3 ширхэг хөрсөнд үл нэвчих, сайжруулсан нийтийн ариун цэврийн байгууламж, хог хурифтлуулах бункер байршуулж, 2022 онд аймгийн хэмжээнд гэр хорооллын айл өрх болон албан байгууллагууд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулсан.

Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламж худалдан авч эвент арга хэмжээнүүдэд ашиглаж байна.

Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн судалгааг гаргаж, тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 12574 нүхэн жорлон, 457 эко жорлон байгаа судалгаа гарсан.

Өлзийт сумын Сангийн далай орчмын 6560 га талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/05 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталсан.

2. 2023 онд Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсэг, Баруунбаян-Улаан, Богд сумдын нутагт орших “Зүүн богд уул”-ын нийт 154.170 га тус тус байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах тухай аймгийн Засаг даргын саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 18/03 дугаар тогтоолоор дэмжсэн.

3. Аймгийн байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа хийлгэх ажлыг 2022 онд ШУА-ийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээр хийлгүүлж, судалгаагаар 61 овгийн 238 төрлийн 517 зүйл ургамал бүртгэгдэж, нэн ховор ургамлын 12 овгийн 13 зүйл ургамлын 48 тархацын цэг, ховор ургамлын 17 овгийн 31 зүйл ургамал, эмийн болон хүнсний ашиглалтад өртөж буй 111 зүйл ургамлын 1059 тархцын цэгийг тогтоосон.

Аймгийн ан агнуурын 2018-2022 оны менежментийн төлөвлөгөөг 2023 онд “Авралын эрэлд” мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүллээ.



4. Аймгийн хэмжээнд 2021-2023 онд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 349,75 га газарт техникийн, 65,9 га газарт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдээр холбогдох стандартын дагуу хийлгэж, нөхөн сэргээсэн талбайг актаар хүлээн авлаа.

5. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос Арвайхээр хотын нэгдсэн хогийн цэг дээр аюултай хог хаягдлыг хадгалах, агуулах байрыг барих барилгын ажил одоогийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

6. Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Жемр” ХХК-иуд хамтран гүйцэтгэсэн.

7. 2021-2023 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал,



орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 19 суманд нийт 80 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцууллаа. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын “Их Булгийн ам” хэмээх газарт 11745.6 м<sup>3</sup> ус бүхий хөв цөөрмийг байгуулсан. Тус хөв цөөрмийн зураг төсвийн ажлыг 2022 онд БОАЖГ-аас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Гидро-Фантан” ХХК-иар гүйцэтгүүлсэн бөгөөд 2023 онд улсын төсвөөр тус хөв цөөрмийн ажлыг “Усны барилга” ХХК гүйцэтгэсэн бөгөөд боомтын урт 83,8 метр, өндөр нь 4,23 метр, хярын өргөн 4 метр бөгөөд мал сүрэг, айл өрхийг ундаалах, байгаль орчны доройтлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм. Хөв цөөрмийг байгуулахад улсын төсвөөс гадна орон нутгийн төсвөөс 390,0 гаруй сая төгрөгийг зарцуулсан бөгөөд “Баянтээг” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд 56,0 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн.

8. Баянтээг түлш” ОНӨХХК 2022 онд 380 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн гэр хорооллын 500 айл өрхийг шахмал түлшээр хангаж байна. Тус үйлдвэрт Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулагдсан. Уг гэрээний дагуу үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалгын төхөөрөмжийн угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Блейз тек” ХХК гэрээ байгуулж, гүйцэтгэл 40 хувь, 300 тн шахмал түлш нөөцлөх агуулахын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Шоо констракшн” ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 70 хувьтай явагдаж, гүйцэтгэлээр ОББҮХ-оос тус тус санхүүжилтээ аваад байна. Мөн ОББҮХ-оос 11 дүгээр сард гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, дэмжлэгийг 660,0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

9. Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ “Хаягдал хуванцар дахин боловсруулах” үйлдвэр байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй Арвайхээр сумын хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслөөр тус суманд пүү болон хоёрдогч түүхий эд хүлээн авах 5 цэгийг шинээр байгуулсан. Уг төслийн хүрээнд бичил тэтгэлэг зарлагдаж, “Эрүүл амьдрал” “Үнсэн блок үйлдвэрлэх” “Хаягдал сүүний савыг дахин ашиглах” зэрэг төслүүдэд тус бүр 5000 ам.доллар, “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг айл өрхүүдэд хэвшүүлсэн. Аймгийн хэмжээнд дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 14 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна.



Аймгийн хэмжээнд 14 сум хоёрдогч түүхий эд пресслэх 21 төхөөрөмжтэй болж улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн 78,5 сая төгрөг зарцуулагдсан байна.

МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр нийт 9 зорилт арга хэмжээ тусгагдаж 97,7 хувьтай хэрэгжсэн байна.

ХЯНАСАН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД  
АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА

